

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019.04.30

Улаанбаатар хот

Хурал 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 17:00 цагт “Хөнгөн бетон” ХК-ийн хурлын өрөөнд эхэлж 18:30 цагт дуусав. Хуралд нэр бүхий 6 хувьцаа эзэмшигч оролцов.

Н.Эрдэмбилэг, Н.Эрдэмбаяр нар гаднаас хувьцаа эзэмшигчдийн хуралд 2 хүн суулгах санал гаргаж оруулж ирэв.

Хурлын дарга Б.Наранзул: хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг бол хувьцаа эзэмшигчид эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчид сууж болно, тийм учраас гадны хүмүүсийг хуралд оролцуулахгүй гэдгийг мэдэгдэв.

Н.Эрдэмбилэг: Бид ТУЗ-ийн гишүүдийг куммлятив аргаар яаж сонгодогийг мэдэхгүй хуулийн мэдлэггүй учраас туслалцаа авах гэсэн зорилготой, бусад хэлэлцэх асуудалд шийдвэр гаргах зэрэгт хөндлөнгөөс оролцохгүй тул хэрэв тус хурал хаалттай биш бол өөрсдийн хуулийн зөвлөхөө хуралд суулгамаар байна гэсэн тайлбарыг өгөв.

Ш. Энхтөр /Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/- Саналын эрх байхгүй юм чинь гол асуудалд хөндлөнгөөс оролцохгүй, зөвхөн ажиглагчаар сууж болно гэхдээ үүнийг хурлын дарга шийднэ.

Н.Эрдэмбилэг: Энэ 2 хүн манай талаас хуулийн зөвлөх хийдэг юм.

Б.Наранзул: Тэгвэл итгэмжлэлтэй орж ирэх ёстой. Итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрөө бие даан энэ хуралд тухайн хүнээ бүрэн төлөөлж асуудалд саналын эрхтэй оролцож болно.

Б.Наранзул: Хурлаар тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох гээд хэлэлцэх асуудлууд тодорхой байгаа, шийдэж болохгүй хэцүү асуудлууд байхгүй.

Н.Эрдэмбилэгийн хуулийн зөвлөх/эмэгтэй: Тийм л дээ, гэхдээ манай үйлчлүүлэгч санал тавьсан учраас бид оролцох эрхтэй гэж бодож байна.

Б.Наранзул: Тэгвэл танд “Хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх” гэрээ байгаа юу?

Н.Эрдэмбилэгийн хуулийн зөвлөх/эмэгтэй: Тэр гэрээг та шалгах эрхтэй хүн биш учраас танд үзүүлэх шаардлагагүй гэж бодож байна.

Б.Наранзул: Надад үзүүлэх шаардлагагүй гэж байвал манай хуралд суух шаардлагагүй. Би хурал даргалж байгаа учраас шалгах эрхтэй.

Н.Эрдэмбилэгийн хуулийн зөвлөх/эрэгтэй: Манай хэдэд ТУЗ-ийн гишүүдийг куммулятив аргаар сонгоход ямар ч хуулийн мэдлэг байхгүй байгаад байна.

Б.Наранзул: ТУЗ-ийн гишүүдийг куммулятив аргаар сонгоно гээд аргачлалыг нь тарааж өгсөн саналын хуудсан дээр тодорхой бичсэн байгаа, тэрнийхээ дагуу л гишүүдийг сонгоно.

Н.Эрдэмбаяр: Өнгөрсөн жилийн хуралд бид шийдвэр гаргахад оролцож чадаагүй учраас хуулийн зөвлөлгөө авах зорилгоор энэ 2 хүнийг оруулж ирсэн юм.

Н.Эрдэмбаяр: Одоо энэ жилээс бид нар хуралдаа хуулийн зөвлөхтэйгээ сууж байя гэж бодсон юм. Тэр нь цаашдаа гарах хурлын шийдвэрт амар байх боловуу. Бид хуулийн мэдлэггүйгээс болж ямар нэгэн буруу шийдвэр гаргах юм бол бид хэн хэндээ хэцүү шдээ.

Н.Эрдэмбилэгийн хуулийн зөвлөх/эрэгтэй: Бид нар ямар нэгэн эсрэг санал гаргаж, эсэргүүцэх юм байхгүй ээ.

Б.Наранзул: Манай бусад хувьцаа эзэмшигч нар зөвшөөрч байгаа юм бол суухыг зөвшөөрье. Харин хурлын шийдвэр, протоколтой танилцах эрхгүй.

Хурлын дарга Б.Наранзул хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулж саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг танилцуулав. Үүнд:
“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны 179373 ширхэг хувьцаа ба ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 177154 ширхэг байгаа ба 99%-ийн ирцтэй байгаа тул хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг нээж байна.

Хуралд оролцсон:

1. Б.Наранзул - 57399
2. Б.Наранцацралт - 26655
3. “Минжит булган гол”ХХК /итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Наранзул/ - 14918
4. Т.Баярхүү /итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Энхтөр / - 1034
5. Н.Эрдэмбилэг -53842
6. Н.Эрдэмбаяр -23306

Тооллогын комиссын ирцийн тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Наранзул: Хурлын ирц хүчин төгөлдөр болсон учраас “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдэе.

Хурлын дэг, дарааллын дагуу ХЭ-ийн хурлаар 3 асуудал танилцуулж хэлэлцэнэ:

- 1) Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 - 2) ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох, цалин урамшууллын талаар,
 - 3) Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах,
- дараа нь эхний 2 асуудал дээр санал хэлэлцээд саналын хуудсаар санал хурааж шийдвэрлэнэ. Үүнд:
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, -/саналын хуудсаар/
 - ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох- /саналын хуудсаар/

Хурлын дарга: Б.Наранзул: Хурлыг дэг, дараалалыг батлах уу?

Н.Эрдэмбаяр: Хурлын дэгийг батлахаас өмнө горимын санал хэлье. Бидний зүгээс 43%-ийн хувьцаа эзэмшдэг, өнгөрсөн жилийн хуралд бид ямар нэгэн байдлаар оролцоогүй учраас бид санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай дэлгэрэнгүй танилцах, цаашлаад компанийн менежментэнд нөлөөлөх тийм нөхцөл байдал үүсч магадгүй учраас эхний ээлжинд ТУЗ-ийн гишүүдээ томилох асуудлаа оруулаад, дараа нь сонгогдсон ТУЗ дээрээ компанийн үйл ажиллагааны тайлангаа хэлэлцвэл ямарвэ гэсэн саналтай байна. Тийм байж болох уу?

Хурлын дарга Б.Наранзул: ХЭ-ийн хурлаар заавал үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж баталдаг, мөн ногдол ашиг хуваарилах талаар танилцуулдаг байгаа. Хурлын хэлэлцэх асуудлын дараалалыг өөрчилж болно, харин хэлэлцэх асуудлыг одоо өөрчилж болохгүй, хэрэв хэлэлцэх асуудал оруулах байсан бол ХЭ-ийн хурал зарлахаас өмнө хэлэлцэх асуудлын саналаа оруулж ирсэн байх ёстой. Өөр санал орж ирээгүй тул ХЭ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг батлаад хувьцаа эзэмшигчид болон Санхүүгийн зохицуулах хороо, МХБиржид хүргүүлсэн байгаа тул дээрх 3 асуудлаас өөр асуудлыг хурлаар хэлэлцэхгүй. Энэ хурлаар заавал үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлана, ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох юм.

Шийдвэрлэсэн нь: Хурлын дараалал, дэгийг өөр санал гаргаагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар батлав.

Асуудал 1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Хурлын дарга Б.Наранзул: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг уншиж танилцуулав. /Тарааж өгсөн материал байгаа/

Өнгөрсөн 5 жилийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан компанийн үйл ажиллагаа асар их доголдолд орсон тул компанийн орлого нэмэгдүүлэх зорилгоор компанийн үл хөдлөх хөрөнгийг бүхэлд нь түрээсэлсэн. Түрээслэгч тал өөр чиглэлийн үйл ажиллагаа явуулж байсантай холбоотойгоор компанийн зүгээс блок үйлдвэрлэн түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлэн өөрсдөө үйлдвэрлэлээ явуулсан боловч татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр зэрэг байгууллагуудын өр төлбөрийн асуудлаас болж хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болон өр төлбөр улам нэмэгдсэн. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж асар хуучирсан учир засварын зардал болон сул зогсолт байнга үүссэн нь хэрэглэгчдийг найдвартай хангах тал дээр асуудал үүссэн. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өөрийн өртөг эдгээр шалтгаануудаас болж өссөн байна. Мөн хэрэглэгчид түлхүү МАК-ийн блокийг хэрэглэж байгаа нь хэрэглэгчдийг хадгалж үлдэхэд хүнд байна. Түрээслэгч компани нэмэр болж байгаа ч бартераар үйлдвэрлэл явуулах тун хэцүү байсан. Одоогийн байдалаар ДЦС-3 болон цахилгаан эрчим хүч г.м газруудад өр төлбөр ихтэй байнгын алданги хүлээдэг. Түрээсийн орлогоор өр төлбөрийг төлж байгаа хэдий ч цалин хугацаандаа тавиагүйгээс болж үндсэн ажилчид тогтвортой ажиллахад хүндрэлтэй байлаа. Өнгөрсөн жил хорих ангиас хоригдлууд авч ажиллуулсан. Ихэнх борлуулалт бартераар явагдаж бартер нь өглөгт явж ирсэн. Шинэ гүйцэтгэх удирдлага томилоод ажиллуулсан боловч компанийн байдал иймэрхүү маш хүнд байсан болохоор цаашид ажиллахад хүндхэн байлаа. Нягтлан бодогч цалинжуулаад ажиллуулах боломж байгаагүй учраас санхүүгийн нягтлан бодох ажил, тайлан балансаа хөндлөнгийн гуравдагч компаниар бартераар блок өгөх нөхцөлтэйгээр хийлгэсэн. Ерөнхийдөө 2-3 инженертэй, хэдэн гэрээт ажилчинтай үйлдвэрлэлээ явуулсан. Өнгөрсөн жил үйлдвэр их оройтож үйл ажиллагаа эхэлсэн, ихэнхдээ зогсонги байдалтай байсан ба 4860м.куб бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, үйлдвэр халаалт байхгүй учраас бүтээгдэхүүний чанар муу гарах тул мөн эрт сул зогсолт хийсэн. Ингээд 635,9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Ихэнх нь бартер байсан учраас өглөгт бартераа өгөөд дахин өр төлбөртэй гарсан байгаа. Компанийн өр өмнөх оныхоос 48,79 сая төгрөгөөр нэмэгдсэн.

2018 оны хувьд нэг амжилттай зүйл нь юу гэвэл зээлтэй байсан Хас банктай бүтэн 2 жил шүүхээр явсаны эцэст барьцаа хөрөнгөө хураалгахгүй байх хэмжээнд аваачсан, дахин 5 жилээр хугацаагаа сунгаад, ам.долларын 11,75%-ийн хүүтэй зээлийг 12%-ийн хүүтэй төгрөгийн зээл болгоод өмнөх хүүгийн хуримтлалаас 600 сая төгрөгийг хасуулсан байгаа. Ханшийн зөрүүнээс болоод төгрөгт шилжсэн зээлийн дүн өмнөх оноос 1,1 тэрбум төгрөгөөр өссөн. Энэ оны 4-р сараас эхлэн үндсэн зээлээс төлөгдөх хуваарьтай байгаа. Оны эцсийн зээлийн хүүгийн үлдэгдэл 329,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба одоогоор төлөгдөөгүй байна. Бүтэн зээлийн хэмжээ нь 3,9 тэрбум төгрөг байгаа.

Гол түүхий эд нийлүүлэгч компанид төлөх байсан олон жилийн өглөгийг хөрөнгө шилжүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан. Одоогоор шилжүүлж чадаагүй байгаа бөгөөд компанийн газар нь банкны барьцаанд байгаа болохоор банкны өр зээл бүрэн төлөгдөж, барьцаа чөлөөлөгдсөний дараа хөрөнгө шилжих боломжтой. Түрээсийн гэрээ нь их хэмжээний хэлцэлд тооцогдох ба жил бүр гэрээг дүгнэн явж байна. Шүүхийн шийдвэр гарсан өр төлбөрүүдийн зарим нь 2019 оны эхний хагас жилийн тайлан балансаар гарч ирэх байх. Зарим өр төлбөрүүд нилээн олон жил болсон өр төлбөрүүд байгаа.

Н.Эрдэмбилэг: Одоо тэгэхээр компанийн гүйцэтгэх удирдлага байхгүй байгаа юу?

Хурлын дарга Б.Наранзул: Гүйцэтгэх захирал байгаа боловч, энэ жилээс ажлаа өгье гэсэн. Ийм байдалтай цаашид ажиллаж чадахгүй гэсэн байгаа.

Н.Эрдэмбилэг: Өнгөрсөн онд ерөнхийдөө үйлдвэрлэл нь аажуухан эхлэсэн үү?

Б.Наранзул: Ер нь нилээн оройтож 5-р сарын 25-наас ажил эхлэсэн. Өнгөрсөн 2017 онд борлуулалтын орлого 400 сая төгрөг байсан бол 2018 онд 600 сая төгрөг болж өссөн боловч өртөг өссөн байгаа. Борлуулалтын орлого бартераар ихэвчлэн явж ирсэн.

Н.Эрдэмбилэг: Борлуулалтын орлого бартераар хэдэн хувьд байсан бэ?

Б.Наранзул: 50-60% хүртэл байсан.

Н.Эрдэмбилэг: Түрээслэж байгаа газар нь ямар газар вэ? Ньюком юм уу?

Б.Наранзул: Үгүй ээ, 2016 онд гаалийн терминалын чиглэлээр үйл ажиллагаа явуулна гэж “Бэст терминал” ХХК манай объектуудыг бүхэлд нь түрээслэсэн байгаа манай хуучирсан агуулах объектуудад засвар үйлчилгээ хийгээд цааш нь давхар түрээслэсэн. Эхний жилийн үрээсийн төлбөртөө хуучин объектуудыг чинь засварлаж янзалж өгье, дараа нь танайд үлдэх хөрөнгө юм гэж тохирсон. Бэст Терминал ХХК-ийн давхар түрээслэж байгаа газрууд гаалийн терминалын зөвшөөрлөө авах хүртэл, мөн танайхыг үйлдвэрийн үйл ажиллагаагаа бүрэн зогсоох хүртэл түр түрээслээд явж байя гэж тохирсон.

Н.Эрдэмбилэг: Сарын түрээс нь хэд вэ?

Б.Наранзул: Тухайн үед буюу 2016 онд гэрээ хийхдээ жилийн 100 сая төгрөг гэж тохиролцсон байгаа, одоо үйл ажиллагаа нь жигдрээгүй л байх шиг байна. 20 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулсан.

Н.Эрдэмбилэг: Түрээсийн төлбөрөө яаж төлж явдаг вэ?

Б.Наранзул: Өнгөрсөн жил бид цахилгааны хуримтлагдсан өр төлбөрөө төлүүлсэн байгаа. Мөн ус, уурын төлбөрийг төлүүлэх зэргээр төлбөр хийлгээд, дараа нь жилийн эцэст тооцоо нийлээд явах байдлаар тохироод явж байна.

Н.Эрдэмбаяр: Гэрээндээ төлбөр тооцоогоо яаж хийнэ гэж заасан бэ?

Б.Наранзул: Жил бүрийн эцэст түрээсийн төлбөр тооцоог дүгнээд явна гэсэн байгаа.

Нэмэлт хэлэх зүйл гэвэл: Хас банкны зээл дээр Б.Наранзул, Наранцацралт бид нар өөрсдийн бүх хувийн хөрөнгөөрөө батлан даалт гаргаж байж зээлийн гэрээг сунгасан учраас өөрсдөө зүтгэхээс өөр арга байгаагүй. Та нар бол энэ компанийн хөрөнгийг хураалгалаа гэхэд ямар ч эрсдэл хүлээхгүй, бид бол хувийн хөрөнгөөрөө эрсдэл хүлээж байгаа учраас аль болох эрсдлийг бууруулахын төлөө л ажиллана. Энэ зээл муу зээлийн ангилалд орсон байгаа.

Н.Эрдэмбилэг: Үлдэгдэл зээлийн хүү сард хэдийг төлөх ёстой байгаа вэ?

Б.Наранзул: Энэ хуримтлагдсан хүү 329,2 сая төгрөг бол 2018 оны 4-р сараас хойш төлөгдөөгүй дүн бөгөөд 2019.04-р сар хүртэл нэмэгдсэн байгаа. Энийг төлчих юм бол 2019 оны 4-р сараас эхлээд үндсэн зээлийн төлбөр сард 120 сая төгрөг төлөөд явах юм. Наранцацралт бид хоёрын зүгээс бас өөр санхүүгийн эх үүсвэр банкинд санал болгоод явж байгаа.

Н.Эрдэмбилэг: Компанийн тайланг хэн бэлтгэсэн бэ?

Б.Наранзул: Гүйцэтгэх захирал нь тайланг бэлтгээд ТУЗ-д танилцуулж хэлэлцээд дүгнэлтийг гаргасан байгаа.

Н.Эрдэмбаяр: Бидний зүгээс анхнаасаа шийдвэр гаргахад оролцъё гээд явж байсан, зарим жил нь оролцож байгаагүй, оролцох боломж олгоогүй ч үе байсан. Жилийн жилд бидний хөрөнгө багасаад, өр төлбөр нь нэмэгдээд байдаг.

Б.Наранзул: 2015 онд хамтарч ажиллая гэж санал тавихад чинь бид татгалзаагүй. Тухайн үед буюу 2014 онд та бүгд энэ компанийн хувьцааг авахдаа санхүүгийн ямар нөхцөлд байдалд байсныг мэдэж байсан, тухайн нөхцөл байдлаас гарахыг хүсээгүй, зориуд бидний ажилд саад учруулж буй мэт өмнөх удирдлагуудын санхүүгийн тайланг шаардсан, тэдгээр хариуцаж байсан хүмүүс нь бүгд нас барсан. Тухайн үед та нарын компаниа бодоогүй шийдвэрээс болж бид өнөөдөр ийм байдалтай байна. Үүнээс гарсан үр дагавараас болж компанийн хөрөнгийг банкны барьцаанд алдах хэмжээнд очсон бөгөөд банктai хувийн батлан даалт гаргасан, хувьцаа эзэмшигч миний хувийн хөрөнгө эрсдэлд орсон.

Та нарын гаргасан шийдвэрээс болж тодорхой хэмжээнд хөрөнгө үнэгүйдсэн, харин хувьцаа эзэмшигч би банкны барьцаанд алдалгүй бүртэн 2 жил тэмцэж, банктай гэрээгээ дахин 5 жилээр сунгасан.

Н.Эрдэмбаяр: Бүх юмыг нэг тал руу нь ярьж болохгүй байхаа. Бид хамтраад ажиллая л гэсэн. Өмнөх жилүүдийн санхүүгийн бүх тайланг шалгая гэсэн боловч та нар тийм боломж гаргаагүй.

Б.Наранзул: Та нар одоо байгаа нөхцөл байдлаар ойлгохгүй дандаа өмнөх юмыг шалгая хүн оруулъя гэж компанийн үйл ажиллагааг гацаадаг, бидэнд тэгэж байх цаг байхгүй. Одоо байгаа нөхцөл байдлаа дүгнээд урагшаа харж явахаас өөр замгүй. Өмнөх ажиллаж хариуцаж байсан хүмүүс нь нас барсан байсан тул хариуцлага хүлээх хүн байхгүй.

Н.Эрдэмбаяр: Бид нар нэгэнт хувьцаа эзэмшиж байгаа юм чинь өмнөх юмаа үзэж шалгах нь зөв гэж бодож байна, нэг талаас ийм байна. Нөгөө талаасаа гэвэл бид чөдөр тушаа болоод байгаа юм шиг, жилийн жилд хамтарч ажиллах гээд ч байгаа юм шиг эсвэл үгүй ч юм шиг ийм байдалтай байгаад байх бид нарт ч гэсэн сонирхол алга байна. Аль эсвэл нэгмөсөн нээлттэй болгоод тодорхой боломжуудыг нь олгоод, биднийг тодорхой хэмжээгээр удирдлагад оруулаад хяналт тавиад санал дүгнэлт гаргаад, гаргасан дүгнэлтийнх нь дагуу шийдвэр гаргадаг бол тэрнийхээ дагуу хариуцлагаа хүлээгээд явдаг болвол яасын, бид бага хувьцаа эзэмшигчид биш учраас бид нар ч гэсэн хөрөнгөнд санаа зовж л байна. Одоо цаашдаа хоёр талдаа ийм байдлаараа байгаад байвал төвөгтэй л байна. Компанийнхаа мэдээллийг бидэнд нээлттэй байлгаад өгчихвөл цаашдаа хамтарч ажиллахад болохгүй юм байхгүй.

Б.Наранзул: Манай компани нээлттэй компани бөгөөд бүх тайлан жилийн жилд СЗХ, МХБ-д очиж байгаа тул хэдийд ч танилцах эрх нь нээлттэй. Эсвэл ийм гарц байж болох юм. Өрөөс танайх 43%-ийг төл, бид 56%-ийг төлөөд энэ компанийг дахиад босгоод дахиж хөрөнгө оруулалт хийгээд явах нэг арга байна. Ингэсэн тохиолдолд бид хамтарч ажиллаж болж байна.

Н.Эрдэмбаяр: Энэ бол боломжгүй л юм байна гэж үзэж байна.

Н.Эрдэмбилэг: Бид компанийн өмнөх ажлын тайлантай танилцаж судалгаа хийж байж мэдээлэл ойлголт аваад цаашид хамтраад явъя гэсэн бодолтой байсан, тэгээд үл ойлголцлоос болоод бид ингээд зогсчихлоо.

Б.Наранзул: Одоо байгаа үйл ажиллагаагаар цаашид энэ өр зээлийг төлж явахад хүндрэлтэй. Энэ жил Хөнгөн бетон ХК нь х-тайлантай явж байгаа, бүх объектоо, түрээслэсэн,

Н.Эрдэмбилэг: Бид одоо ингээд ТУЗ-д ороод явахаар асуудлуудаа тодорхой ойлгомжтой нээлттэй ярилцаад явчихвал бид нарын зүгээс хөрөнгө оруулах шаардлагатай юу үгүй юу гэдгээ яримаар байна.

Б.Наранзул: Түрээслэгч энд хамаг хөрөнгөө хийчихсэн, давхар түрээслүүлчихсэн, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө хөөцөлдөөд хүлээж байна Энэ компанийг худалдаад авах юм уу хөрөнгө оруулах газар гарч ирвэл бүгдээрээ ярилцаад тохиролцож болох юм. Бид бас өөр эх үүсвэрээс энэхүү банкны өр төлбөрийг төлөхөөр хөөцөлдөж байгаа.

Н.Эрдэмбилэг: Хурлын материалыг харахаар энэ үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт хангалтгүй санагдаж байна, гүйцэтгэх удирдлага шаардлага хангаж байна уу үгүй юу?

Б.Наранзул: Гүйцэтгэх удирдлага цаашид ажиллахгүй, ажлаа өгье гэсэн байгаа. Энэ дүгнэлтийг хуучин ТУЗ-ийн хурлаар оруулаад хэлэлцчихсэн учраас ТУЗ-ийн дүгнэлтийг л энд оруулж ирсэн байгаа. Ийм маягаар л бид он удаан жил дүгнэлтээ гаргасаар л ирсэн.

Ш.Энхтөр /Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Компанийн байдал хэцүү, өр төлбөртэй, маш хүнд нөхцөлтэй байхад эндээс сайхан тоо баримт харна гэж юу байхав дээ, санхүүгийн балансаа л харчихгүй юу даа, тэгээд бүх юм ойлгомжтой.

Н.Эрдэмбилэг: Эндээс харахад өр төлбөр нь компанийнхаа хөрөнгөнөөс давчихсан тохиолдлыг яриад л байна л даа. Татан буулгах, эсвэл дахин хөрөнгөжүүлэх асуудал

байна байх тийм үү. ТУЗ-ийн гишүүдээ сонгочихоод, татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх талаар нээлттэй ярилцах нь зүйтэй байх.

Н.Эрдэмбаяр: Бид энэ компанийн үйл ажиллагаанд дүгнэлт хийхийн тулд өнгөрсөн хугацааны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээлэл, материалтай танилцах эрхтэй байх гэж бодож байна.

Б.Наранзул: Та нар танилцах эрхтэй, СЗХ, МХБ, компани дээр бүгд байж байгаа. Цаасан материалыг мэйлээр явуулж байсан, та нар танилцах эрхтэй, түүнийг шалгаж хянах нөхцөл бололцоо зөндөө байсан. Өнгөрсөнтэйгээ зууралдаад урагшаа харахгүй юм бол хамтрахад хүнд л юм байна.

Н.Эрдэмбилэг: Хэдүүлээ компани татан буулгах талаар ХЭ-ийн хурлаараа ярилцах уу?

Б.Наранзул: Одоо татан буулгах талаар энэ хурал дээр ярилцахгүй. Зөвхөн дүгнэлтээ батлана, дараа нь ТУЗ-ийн гишүүд шинээр сонгох асуудал байгаа. Ээлжит хурлын дараа л дараагийн ХЭ-ийн хурлаар ТУЗ-д хэлэлцэх асуудлаар саналаа өгснөөр дахин ээлжит бус ХЭ-ийн хурлыг зарлаж болно.

Ш.Энхтөр /Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Энэ удаа зөвхөн тайлангийн дүгнэлтээ л ярьж батлана. За би бол үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлая гэсэн саналтай байна.

Б.Наранцацралт: Би бас батлая гэсэн саналтай байна.

Б.Наранзул: Тайлангийн дүгнэлтийг батлах саналтай байна.

Н.Эрдэмбилэг: Би татгалзаж байна.

Н.Эрдэмбаяр: Би бас татгалзаж байна.

Хурлын дарга: Б.Наранзул: Та нар үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах эсэх саналаа саналын хуудсаар бөглөөд тооллогын комисст өгөөрэй.

Асуудал 2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах нь

Хурлын дарга Б.Наранзул:

“Хөнгөн бетон” ХК нь 2018 онд алдагдалтай ажилласан ба банкны өмнө хүлээсэн зээлийн гэрээний үүргийн дагуу ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа гэдгийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хурлын дарга: Б.Наранзул: Энэ асуудал дээр санал хураахгүй.

Асуудал 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хурлын дарга Б.Наранзул: Өмнөх ТУЗ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, эрхгүй болсон тул энэ удаагийн ХЭ-ийн хурлаар шинэ ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлсэн саналыг танилцуулж байна. Анкетыг танилцуулав. /тараах материал өгсөн бөгөөд гишүүн тус бүрээр анкеттэй нь танилцана уу.

а/ ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Тошил овогтой Баярхүү
2. Баярхүү овогтой Наранзул
3. Баярхүү овогтой Наранцацралт
4. Баасанжав овогтой Мөнхцацралт
5. Нэмэхбаатар овогтой Эрдэмбилэг
6. Нэмэхбаатар овогтой Эрдэмбаяр

б/ ТУЗ-ийн хараат бус гишүүд:

7. Бямбасүрэн овогтой Батболд
8. Шаравсамбуу овогтой Энхтөр
9. Доржпүрэв овогтой Энхнаран

Хурлын дарга Б.Наранзул: ТУЗ-ийн гишүүдийг куммулятив аргаар сонгоно, нэр дэвшсэн хүмүүст өгөх саналын тоогоо өгөөд саналаа хураая. /Саналын хуудсаа тараав./ Куммулятив аргын тухай саналын хуудасны доод хэсэгт тайлбар бичсэн байгаа, тэр тайлбарыг уншаад зааврын дагуу саналаа бөглөөрэй. (Ер нь бол өөрийнхөө хувьцааны тоог 9 сонгогдох гишүүний тоогоор үржүүлээд, санал өгөх гишүүнийхээ тоонд хуваана.)

Н.Эрдэмбилэг: ТУЗ-ийн хараат бус 3 гишүүний анкетыг яаж бүрдүүлж авсан бэ? Яаж сонгосон бэ? Одоо хараат бус гишүүн дээр өөр хүн санал болгож болох уу

Хурлын дарга Б.Наранзул: Одоо бол нэр дэвшүүлэх хүний анкет шинээр авахгүй. анкетаа ирүүлсэн гишүүдээс сонгоно. Одоогоор 9 гишүүний анкет ирсэн байна. Ердийн гишүүнд 6 хүн, хараат бус гишүүнд 3 хүн байна. Энэ 9 гишүүндээ саналаа өгнө. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх анкетээ манайд өгнө үү гэж санал тавиад, тэгээд хүмүүс анкетаа ТУЗ-ийн нарийн бичигт авчирч өгсөн байгаа.

Н.Эрдэмбилэг: Бид нар нэгэнт хуулийн зөвлөхөөс зөвлөлгөө аваад явж байгаа учраас хараат бус гишүүнийг хуулийнх нь дагуу нэр дэвшүүлж сонгомоор байна.

Хурлын дарга Б.Наранзул: Өр төлбөртэй хүнд байдалтай байгаа энэ компанид хараат бус гишүүнд хүмүүс саналаа өгч сайн дураараа ирэхгүй байна, бид аман зараар манай ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэрээ дэвшүүлээч гээд ирүүлсэн 2 хүний анкетыг авсан. Танайхаас 1 хүнийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлсэн гэж ойлгосон.

Н.Эрдэмбилэг: 10 минутын завсарлага авъя гэв.

10 минут завсарлаад ТУЗ-ийн гишүүд сонгох саналын хуудсаа бөглөв.

Н.Эрдэмбилэг: Энэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшүүлэх санал дээр манайхаас ердийн гишүүнд 3 хүн байгаа, Батболдыг хараат бус гишүүн дээр тавьсан байх юм? Манай ирүүлсэн бичгийг дахиад хардаа, /ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хэлэв/

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ундрах: Танайхаас 2019.02.15-ны өдөр ирүүлсэн нэр дэвшүүлэх 3 хүний анкет болон саналын бичиг энэ байна, үүн дээр ердийн гишүүнд гэж ерөөсөө зааж өгөөгүй байна. Би үүнийг Эрдэмбилэг, Эрдэмбаяр 2-ыг хувьцаа эзэмшигч учраас ердийн гишүүнд, Батболдыг хувьцаа эзэмшдэггүй гэж бичсэн байсан тул хараат бус гишүүнд өмнө нь нэр дэвшүүлж байсантай адил нэр дэвшүүлж байгаа юм байна гэж ойлгосон.

Б.Наранзул: Ирүүлсэн анкетуудыг шалгаад хуульд заасан хараат бус гишүүний шаардлагыг хангаж буй эсэхийг шалган шаардлага хангасан анкеийг ХЭ-ийн хуралд оруулж ирсэн байгаа. 3 хараат бус гишүүний орон тоонд 3 анкет ирсэн.

Н.Эрдэмбилэг: Бид хоёр санал өгөх хуудсан дээр Батболдыг анхнаасаа ердийн гишүүнд сонгох хүсэлтэй байсан тул хараат бус гишүүн дээр саналаа буулгаад зөвхөн өөрсдөд дээрээ саналаа хуваагаад өгч байна.

Н.Эрдэмбилэг: Би нэг санал хэлье. Хараат бус гишүүнээ яаж сонгосон талаар тодорхойгүй байна, тиймээс үүн дээр саналаа өгөх боломжгүй байна. Хуулиараа бол нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлээд явах ёстой байсан байх.

2-рт санхүүгийн тайлангаас харахад өр нь компанийнхаа хөрөнгийн 25%-иас давсан байна. Ийм тохиолдолд санхүүгийн тайланг тавьсанаас хойш 10 хоногийн дотор компанийн тухай хуулиараа бол ТУЗ нь татан буулгах эсвэл дахин хөрөнгөжүүлэх гэж хурлыг зарлана гэсэн байдаг, энэ нь зөрчигдөөд явсан байх шиг байна.

Ш.Энхтөр /Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Энэ асуудал хэлэлцэх асуудалд ороогүй учраас хэлэлцэхгүй.

Хурлын дарга Б.Наранзул: Одоо энийг хэлэлцэх асуудалд ороогүй учраас энэ хурлаар хэлэлцэхгүй ээ.

Хурлын дарга Б.Наранзул:

1) 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №01 тоот “Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай” тогтоолын төслийг танилцуулав.

2) 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №02 тоот “ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж, шинээр сонгох болон гишүүдэд цалин олгохгүй тухай” тогтоолын төслийг тус тус танилцуулав.

Ш.Энхтөр /Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Хэлэлцсэн асуудлын тогтоолын төсөл дээр хэлэх санал алга байна.

Н.Эрдэмбаяр: За бид ч гэсэн ерөнхийдөө ТУЗ-өө ингээд саналын дагуу байгуулчихъя. Тэгээд ТУЗ-ийн зүгээс компанийн гүйцэтгэх захирал, санхүүгийн захирал, нябо томилоход ямар үүрэг өгөх ёстой юм, тэр бүгдийг хуулийн дагуу дүрмээрээ яваад үзье гэж бодож байна.

Хурлын дарга Б.Наранзул: Энэ асуудлыг ТУЗ-ийн хурлаараа шийдэх асуудал юм.

Хурлын дарга Б.Наранзул: Тооллогын комисс саналын хуудсуудыг авч нэгдсэн дүнгээ гаргаад саналын тоог танилцуулаарай.

ТУЗ-ийн гишүүнийн цалин урамшууллын талаар

Хурлын дарга: Б.Наранзул: Компанийн нөхцөл байдал хүнд, өр зээл ихтэй, алдагдал ажиллаж байгаа зэргээс шалтгаалаад ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал өгөх ямар ч боломж бололцоогүй байна. Тиймээс энэ жил ТУЗ-ийн гишүүдэд цалингүй байхыг дэмжиж байна уу?

Ш.Энхтөр/Т.Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Компанийн ажил цэгцэртлээ цалингүй байхыг зөвшөөрч байна.

Б.Наранцацралт: Би ч гэсэн адилхан.

Б.Эрдэмбилэг: Дэмжиж байна.

Н.Эрдэмбилэг: Дэмжиж байна.

Б.Наранзул: мөн адил дэмжиж байна. Хуралд оролцсон бүх хувьцаа эзэмшигчид дэмжиж байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтантуяа: Саналын хуудсыг нэгтгэн тооллоо. Үүнд:

- 1) Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлахад саналын хуудсаар санал хураахад хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 56% зөвшөөрсөн, 43% нь татгалзсан байна.
- 2) ТУЗ-ийн ердийн ба хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг куммулятив аргаар санал хураахад :

Ердийн гишүүд:

Д/д	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Тошил овогтой Баярхүү	150010
2	Баярхүү овогтой Наранзул	150010

3	Баярхүү овогтой Наранцацралт	150010
4	Баасанжав овогтой Мөнхцацралт	150008
5	Нэмэхбаатар овогтой Эрдэмбилэг	347166
6	Нэмэхбаатар овогтой Эрдэмбаяр	347166

Хараат бус гишүүд:

д/д	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Бямбасүрэн овогтой Батболд	1
2	Шаравсамбуу овогтой Энхтөр	150010
3	Доржпүрэв овогтой Энхнаран	150010

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дээрхи саналын эрхийн тоогоор тус тус санал авч, ТУЗ-ийн ердийн гишүүн ба хараат бус гишүүнээр сонгогдов.

Б.Наранзул: За ингээд хэлэлцэх асуудал дууссан тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье.

Тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Б.Ундрах

Хурлын тэмдэглэлтэй танилцсан: Хувьцаа эзэмшигчид:

1. Б.Наранзул Б.Наранзул
2. Н.Эрдэмбилэг
3. Б.Наранцацралт Б.Наранцацралт
4. Н.Эрдэмбаяр
5. Б.Наранзул “Минижит булган гол” ХХК, /түүнийг төлөөлж Б.Наранзул/
6. Т.Баярхүү Т.Баярхүү, /түүнийг төлөөлж Ш.Энхтөр/ -г

Протокол хөтөлсөн хурал дээр эрийнхний газруудад тодорхой бүрэн хөтөлсөний, зарим зүйл авсан. Ажлынх асуудлууд дээр хэрэв саналтай байгаа. Санхүү аргаар өгсөн, алдагдалтай үйл ажиллагаа бүтээсэн тул асуудал дээрх шаардлагатай гэм үзэн байна.

Хурлын тэмдэглэл: Н. Эрдэмбилэг

2019.05.09

